

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ
БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

№	Удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэг	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1480 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024- 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 27-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газар хүргүүлсэн. - Нийслэлийн хөгжлийн 2025 оны хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн газарт хүргүүлсэн.	100%
2	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;	- Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд 4 арга хэмжээ тусгаж хэрэгжилт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц, хөгжлийн бодлогын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны 301 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд 1 арга хэмжээ тусгаж хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц, хөгжлийн бодлогын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны 300 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100%
3	Байгууллагын албан хаагчийн хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах;	Гүйцэтгэх захирлын 2025 оны А/19 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны гишүүд, ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж нийт ажилчид хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн шинэчлэн баталсан Албан тушаалын тодорхойлолтын 3.8, Хөдөлмөрийн гэрээний 2.4.1-т ёс зүй	100%

		сахилга хариуцлагатай холбоотой заалтыг оруулж мөрдлөг болгож байна.	
4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран заржуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	2025 оны төсөвт 800 сая төгрөгийг батлуулан авсан. Батлагдсан төсвийн хүрээнд өр авлагагүй ажиллаж байна. 2014 онд Бизнес хөгжлийн төвөөс балансаас баланст шилжин ирсэн хариуцагч нь олдохгүй байгаа найдваргүй өр 86,0 сая төгрөг, авлага 9,291.0 мянган төгрөгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан хүчингүй болгох шийдвэрийг гаргуулан данс бүртгэлээс хассан.	90%
5	Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх ба байгууллагын чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргыг шүүхийн байгууллагын өмнө төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	Монгол Улсын хуулийн этгээд болох “Нитро Сибирь-Монголиа” ХХК нь Нийслэлийн Засаг даргад холбогдуулан Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр нэхэмжлэл гаргасан. Тус шүүхэд Парк нь гуравдагч этгээдээр оролцож 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 128/Ш32025/3213 дугаартай нэхэмжлэлийг буцаах тухай шүүгчийн захирамж гарсан боловч “Нитро Сибирь-Монголиа” ХХК нь дахин нэхэмжлэл гаргаж одоо хүртэл шүүхийн маргаантай байгаа болно.	50%
6	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуйн асуудлаар Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй хамтран ажиллах;	НИТХ-ын 2016 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан 120 га газрын ХЕТ, 2025 оны БХБЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр батлагдсан 130 га газрын ХЕТ-ны дагуу аж ахуйн нэгжүүдийг байршуулан үйл ажиллагаа явуулж байна. Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд паркт байршсан үйлдвэр аж ахуй нэгжийн А даалгавар болон барилгын зураг батлуулахаар Хот байгуулалт хотын стандартын газарт хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлж байна.	100%
7	Шаардлагатай тохиолдолд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга батлахаар заасан захиргааны хэм хэмжээний актыг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33, 2025 оны 25/50 дугаар тогтоолоор манай компанийн дүрмийн сангийн хөрөнгийг баталсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Захирамж гаргуулахаар холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж НЗДТГ-т хүргүүлсэн. 2025 оны А/126, А/822 дугаар “Санхүүжилтийн	100%

	Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	тухай” тус тус захирамжийг гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
8	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж бодит үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллаж байна. Паркийн 250 га газар дээр нийт 35 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 18 аж ахуйн нэгжтэй шинэ гэрээ хийсэн. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 6 аж ахуйн нэгж нь хар, цагаан замаска 1056 тн, ширэм болон ган боловсруулах 150 тн утас, 400 тн ган бөмбөлөг, хар тугалган хүхрийн хүчлийн батарейг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулсан байна. Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүд нь нийслэл дүүргийн татварт 941,000,000 төгрөгийн татвар төвлөрүүлж, 174 иргэнийг түр болон байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.	100%
9	Ажилтны сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;	Албан хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан 7 удаагийн сургалтад давхардсан тоогоор 10, дотоод сургалтыг 8 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 56 албан хаагчийг хамруулсан.	100%
10	Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр нь хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж хугацаанд шуурхай хариуг нь хүргүүлсэн. Шийдвэрлэлтийн мэдээ тайланг улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний нэгдсэн төвд албан бичгээр мэдээлсэн. Аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн сар бүр тогтмол ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг гаргаж байна. Мэдээллийн ил тод байдлыг хангаж цахим сайтаар мэдээлсэн.	100%

11	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн дотоод аудитаас 2023-2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудит орсон. Энэ шалгалтаар 9 зөвлөмж 1 акт авч ажилласан. Зөвлөмжийн биелэлт гарган хүргүүлж, 200,000 төгрөгийн актыг бүрэн барагдуулсан. Нийслэлийн дотоод аудитын газраар 2025 оны “Шилэн данс”-ны мэдээлэл байршуулалт, ил тод мэдээлсэн байдалд шалгалт хийдэж ажилттай шалгуулсан. 1 зөвлөмж авч шалгалтын явцад бүрэн залруулан ажилласан. 2025 оны Санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн аудитаас санал дүгнэлт авахаар хувиарлагдсан. Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын үзлэг шалгалт хийгдэж, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/29 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлыг ханган ажилласан. Хуваарийн дагуу улсын үзлэгт 2020-2025 оны баримт бичгийг шалгуур үзүүлэлт тус бүрээр шалгуулан архив - 91.3%, албан хэрэг хөтлөлт – 89,7%, ажлын зохион байгуулалт 92,2% нийт улсын үзлэг шалгалтаар 91 хувиар үнэлэгдсэн.	100%
12	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах;	Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлт болох Хог хаягдлын менежментийн түвшин дэд үзүүлэлтийн хүрээнд парк нь Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийг байршуулан ажиллаж байна. Тэдгээр үйлдвэрүүд нь: Ашиглалтаас хасагдсан хар тугалгад хүхрийн хүчлийн батарейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS6783:2019 стандартыг баримтлан дахин боловсруулж 99.97%-с дээш цэвэршилттэй хар тугалга, цэвэр гөлтгөнө болон хуванцар эдлэл үйлдвэрлэдэг. 2025 онд 2500 тн хар тугалга экспортод гаргасан. Том машины 30,000 хаягдал дугуй дахин боловсруулж 1126 тн резиний үйрмэг болгон экспортод гаргасан. Мөн 400 тн торосс буюу хаягдал төмрийг дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн.	100%

		40 тн электроникийн хаягдал, 60 тн хаягдал зэсийг худалдан авч дахин боловсруулж 60 катодын зэс хавтан үйлдвэрлэж экспортод гаргасан. Хаягдал төмөр, хөнгөн цагаан болон зэсийг худалдан авч сард 150 тн зэс утас, 400 тн ган бөмбөлөг үйлдвэрлэж экспортод гаргадаг. Газар ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах чиглэлээр: -Суурьшлын бүсээс зайтай үйлдвэр үйлчилгээ дэд бүтэц хөгжөөгүй газарт үйлдвэрлэлийн бүсийг бий болгож нийт 15 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Тэдгээр үйлдвэрүүд нь Улаанбаатар хотын төвийн төвлөрлийг сааруулж, агаар ус орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд үйлдвэрлэлийн бүсэд шилжин ирээд байна. -Тээвэр логистикийн бүс байгуулахтай холбогдуулан Төв аймгийн Сэргэлэн сумын Баян зөрлөгөөс парк хүртэлх 11,7 км төмөр зам байгуулахаар Төв аймгийн Засаг даргын 2025 оны А/600 дугаар “Газар ашиглуулах тухай” захирамжийг гаргуулсан.	
13	Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зай болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тогтоох;		0%
14	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай үр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;	2025 оны 04 сарын 18-ны өдөр 12 паркийн нэгжтэй уулзалт зохион байгуулж Хот төлөвлөлт, хот байгуулалтын стандартын барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0301B-г танилцуулан мэдээлэл өгсөн.	100%

15	Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;	2025 онд ШУТИС-тай хийгдсэн Санамж Бичгийн хүрээнд Хөгжлийн төлөвлөгөө 2025-2040 Менежментийн сургуулийн эрдэмтдийн багтай гэрээ байгуулан хийсэн. Тус судалгааны ажлын тайланг үндэсний судалгааны нэгдсэн платформ sudalгаа.gov.mn-д болон байгууллагын пэйж хуудас, вэб сайтад байршуулсан.	100%
16	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэлийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	Иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн. Шийдвэрлэлтийн мэдээг тухай бүр вэб хуудсанд байршуулдаг. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоног байна.	100%
17	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр нь биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2025 онд зохион байгуулагдсан Нийслэлийн удирдах ажилтнуудын 25 удаагийн шуурхай хуралдаанд хамрагдаж үндсэн хэрэгжүүлэх 2 үүрэг даалгавар, хамтран хэрэгжүүлэх 50 үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж тайлагнасан. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн чиглэл, арга хэмжээг зохион байгуулж хугацаа хэтрэлтгүйгээр хариуг шуурхай өгч ажилладаг.	100%
18	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт 47 арга хэмжээ төлөвлөж 2025 оны жилийн эцсийн байдлаар биелэлт 94%-тай Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2025.12.03-ны 315 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100%
19	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;	Байгууллагын даргын шийдвэрийг тухай бүр вэб хуудсанд байршуулсан. Байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллаж байна.	90%
20	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан	90%

	худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	авах ажиллагааны төлөвлөгөө батлуулан биелэлтийг хангаж ажиллаа. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хагаж 2025 оны 12 сарын байдлаар 156 мэдээллийг бүрэн оруулсан. Шилэн дансны 4-р улирлын нэгдсэн тайланг бүрэн илгээлээ. Нийслэлийн дотоод аудитын хэлтэст шилэн дансны хуулийн хэрэгжлтийг шалгуулж 1 зөвлөмж гарсанг зассаж бүрэн хэрэгжүүлэн ажилласан.	
21	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах;	Гадаад харилцааны үйл ажиллагаа явуулах чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хандаж 2 удаагийн Гадаад томилолтын захирамж гаргуулан, захирамжийн биелэлт, ажлын тайланг тухай бүр тайлагнасан.	100%
22	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар мэдээ пэйж хуудсаар түгээгдэж буй Улаанбаатар хот 2025-2028 онд хэрэгжүүлэх 24 мега төслийг өөрийн пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан түгээсэн.	100%
Биелэлтийн дундаж хувь			91,5%

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ПҮРЭВСҮРЭН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРТУЯА


	худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	авах ажиллагааны төлөвлөгөө батлуулан биелэлтийг хангаж ажиллаа. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хагаж 2025 оны 12 сарын байдлаар 156 мэдээллийг бүрэн оруулсан. Шилэн дансны 4-р улирлын нэгдсэн тайланг бүрэн илгээлээ. Нийслэлийн дотоод аудитын хэлтэст шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуулж 1 зөвлөмж гарсанг зассаж бүрэн хэрэгжүүлэн ажилласан.	
21	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах;	Гадаад харилцааны үйл ажиллагаа явуулах чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хандаж 2 удаагийн Гадаад томилолтын захирамж гаргуулан, захирамжийн биелэлт, ажлын тайланг тухай бүр тайлагнасан.	100%
22	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Улаанбаатар мэдээ пэйж хуудсаар түгээгдэж буй Улаанбаатар хот 2025-2028 онд хэрэгжүүлэх 24 мега төслийг өөрийн пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан түгээсэн.	100%
Биелэлтийн дундаж хувь			91,5%

ХЯНАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Н.ПҮРЭВСҮРЭН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.БОЛОРТУЯА